

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/17-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум 2024 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
	Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-2442 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12-13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13-14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14-17
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17-20
4. Аудитын тайлан	
4.1 Ерөнхий зүйл	21
4.2 Материаллаг байдал	21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	21-22
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	22
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22-23
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	23
5. Аудитын илрүүлэлт	24-26
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	27-28

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГБХЗХГ	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТАМАТ	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ХХС	Хоршоог хөгжүүлэх сан
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ШААМАР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ Д.СЭРГЭЛЭН ТАНАА

2024.03.25 № 00А-2024/03-НА-СТА-ОНА
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн Шаамар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 23,134.9 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 25 дугаар зүйлийн 25.2, 44 дүгээр зүйлийн 44.4, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.4.2, 14.4.3, 20 дугаар зүйлийн 20.2.5-д заасантай болон Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 2.1, 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3.3, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалын 4.2, 2021 оны

190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай тус тус нийцээгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Сумын ИТХ-ын “Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 2023 оны төсөвт тодотгол хийх тухай” 94 дүгээр тогтоолоор тайлант онд нийт 769,019.0 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 869,657.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг 13.1 хувиар давуулан биелүүлсэн байна.

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 86.4 хувьтай тайлагнагдан, батлагдсан төсвийг 13.6 хувиар хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн “Захирамж хүчингүй болгох тухай” А/99 дугаар захирамжаар Шаамар сумын Засаг даргаар Фазылын Серикболыг томилсон 2020 оны Б/83 дугаар захирамжийг хүчингүй болгосон байна.

Шаамар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Ф.Серикболыг дахин нэр дэвшүүлж ирснийг аймгийн Засаг дарга хүлээн авч 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн Б/11 дүгээр захирамжаар сумын Засаг даргаар томилсон байна.

Мөн аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн “Захирамж хүчингүй болгох тухай” Б/30 дугаар захирамжаар Шаамар сумын Засаг дарга Ф.Серикболыг томилсон 2023 оны Б/11 дүгээр захирамжийг хүчингүй болгосон байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн Б/32 дугаар захирамжаар Шаамар сумын Засаг даргын албан үүргийг сумын Засаг даргын орлогч Д.Сэргэлэнд хариуцуулснаар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үүрэг гүйцэтгэж, төсөв, хөрөнгийг захиран зарцуулж ирсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус сум нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 20 зорилтын хүрээнд 186 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 76.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	938,436.6	1,028,837.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	411,835.6	318,496.2
33	АВЛАГА	216,071.5	200,343.8
35	БАРАА МАТЕРИАЛ	310,529.5	509,997.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,920,109.7	6,475,855.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,920,109.7	6,475,855.5
39200	Биет хөрөнгө	4,786,501.8	6,342,410.2
39300	Биет бус хөрөнгө	133,607.9	133,445.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,858,546.3	7,504,693.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.0	154.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	154.9
41300	Өглөг	0.0	154.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,858,546.3	7,504,538.4
51	Засгийн газрын хувь оролцоо	5,858,546.3	7,504,538.4
51100	Засгийн газрын оруулсан капитал	693,139.5	693,139.5
51200	Хуримтлагдсан үр дүн	3,595,549.0	5,241,541.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,569,857.8	1,569,857.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,858,546.3	7,504,693.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,410,336.4	4,248,625.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	505,883.7	619,167.2
110	Орлогын албан татвар	319,712.5	407,870.0
1100	Хувь хүний орлогын албан татвар	319,712.5	470,788.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-62,918.1
113	Хөрөнгийн албан татвар	58,585.7	47,884.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	127,585.6	163,412.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	375,381.3	1,839,047.8
120	Нийтлэг татварын бус орлого	375,381.3	1,839,047.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,529,071.4	1,790,410.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,380,990.6	2,313,498.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,380,990.6	2,313,498.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,362,782.4	2,311,098.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	508,355.4	663,277.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,697.5	82,988.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	454,883.6	157,910.2

2104	Хангамж, бараа материалын зардал	47,137.7	206,485.1
2105	Нормативт зардал	200.0	2,547.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	78,488.0	20,969.6
2107	Томиллолт, зочны зардал	3,402.5	4,856.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,621.2	665,720.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	170,996.6	506,343.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,208.1	2,400.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,029,345.8	1,935,127.3
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	8,854,487.6	289,135.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-7,825,141.8	1,645,992.1

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	13,687,173.3	0.0	13,687,173.3
10	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	5,858,546.3	0.0	5,858,546.3
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,683,688.1	0.0	13,683,688.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-3,485.3	0.0	-3,485.3
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	-7,825,141.8	0.0	-7,825,141.8
11	2023 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	5,858,546.3	0.0	5,858,546.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,858,546.3	0.0	5,858,546.3
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	1,645,992.1	0.0	1,645,992.1
20	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	7,504,538.4	0.0	7,504,538.4

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,223,344.0	2,690,951.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	505,883.7	619,167.2
110	Орлогын албан татвар	319,712.5	407,870.0
1100	Хувь хүний орлогын албан татвар	319,712.5	470,788.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-62,918.1
113	Хөрөнгийн албан татвар	58,585.7	47,884.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	127,585.6	163,412.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	65,643.3	82,396.2
1181	Газрын төлбөр	59,337.0	77,754.8
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,605.2	3,261.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	208,726.8	304,288.0
120	Нийтлэг татварын бус орлого	208,726.8	304,288.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,508,733.4	1,767,496.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,480,904.3	1,784,863.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,480,904.3	1,784,863.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,459,865.3	1,782,463.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	540,987.6	662,169.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,295.3	82,894.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	508,883.6	158,216.0
2104	Хангамж, бараа материалын зардал	56,788.3	80,580.2
2105	Нормативт зардал	200.0	2,547.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	100,263.6	29,153.4
2107	Томиллолт, зочны зардал	3,670.5	4,856.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,737.5	678,735.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	120,038.9	83,311.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,039.0	2,400.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	742,439.6	906,088.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	607,621.9	999,427.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	607,621.9	999,427.9
2200	Дотоод эх үүсвэрээр	607,621.9	999,427.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-607,621.9	-999,427.9
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	122,817.8	-93,339.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	289,017.8	411,835.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	411,835.6	318,496.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,889,186.40	2,496,010.73	393,175.67	86.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,886,318.60	1,752,947.79	133,370.81	92.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,881,765.60	1,750,547.79	131,217.81	93.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	695,963.00	661,384.18	34,578.82	95.03
210101	Үндсэн цалин	518,579.60	483,777.35	34,802.25	93.29
210102	Нэмэгдэл	169,851.60	155,108.18	14,743.42	91.32
210104	Урамшуулал	7,531.80	22,498.65	-14,966.85	298.72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,165.70	82,894.13	4,271.57	95.10
210201	Тэтгэврийн даатгал	59,297.10	56,254.25	3,042.85	94.87
210202	Тэтгэмжийн даатгал	6,966.80	6,767.26	199.54	97.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,574.10	5,523.92	50.18	99.10
210204	Ажилгүйдлийн даатгал	1,393.30	1,347.86	45.44	96.74
210205	Эрүүл мэндийн даатгал	13,934.40	13,000.83	933.57	93.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	751,416.70	718,915.11	32,501.59	95.67
210301	Гэрэл, цахилгаан	94,792.60	74,845.19	19,947.41	78.96
210302	Түлш, халаалт	626,189.80	623,460.88	2,728.92	99.56
210303	Цэвэр, бохир ус	30,434.30	20,609.05	9,825.25	67.72
2104	Хангамж, бараа материалын зардал	85,227.10	73,146.83	12,080.27	85.83
210401	Бичиг хэрэг	10,864.20	10,546.65	317.55	97.08
210402	Тээвэр, шатахуун	39,418.40	35,640.82	3,777.58	90.42
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,228.60	5,368.96	1,859.64	74.27
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,014.80	5,905.05	6,109.75	49.15
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,701.10	15,685.35	15.75	99.90
2105	Нормативт зардал	552.80	494.00	58.80	89.36
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	552.80	494.00	58.80	89.36
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	58,449.60	57,194.55	1,255.05	97.85
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,565.00	14,263.30	2,301.70	86.11
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	622.60	622.60	0.00	100.00
210604	Урсгал засвар	41,262.00	42,308.65	-1,046.65	102.54
2107	Томилолт, зочны зардал	6,524.80	4,856.50	1,668.30	74.43
210702	Дотоод албан томилолт	6,524.80	4,856.50	1,668.30	74.43
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	96,587.70	76,188.72	20,398.98	78.88
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	92,060.60	73,743.22	18,317.38	80.10
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	321.10	0.00	321.10	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	224.40	102.38	122.03	45.62
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,269.10	352.93	916.17	27.81
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	86.70	55.00	31.70	63.44
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,070.70	1,695.10	375.60	81.86

210807	Газрын төлбөр	451.90	136.90	315.00	30.29
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	103.20	103.20	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	99,878.20	75,473.78	24,404.43	75.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	95,936.10	72,084.33	23,851.78	75.14
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,942.10	3,389.45	552.65	85.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,553.00	2,400.00	2,153.00	52.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,553.00	2,400.00	2,153.00	52.71
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,900.00	1,900.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,653.00	500.00	2,153.00	18.85
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	937,347.80	743,062.94	194,284.86	79.27
220001	Барилга байгууламж	12,155.60	12,155.60	0.00	100.00
223001	Бусад хөрөнгө	925,192.20	711,707.34	213,484.86	76.93
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	65,520.00	0.00	65,520.00	0.00
230001	Эргэж төлөгдөх зээл	65,520.00	0.00	65,520.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,889,186.40	2,558,865.30	330,321.10	88.57
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,476,186.40	2,505,067.17	-28,880.77	101.17
320001	Орон нутгийн төсвөөс	2,257,793.70	2,272,644.07	-14,850.37	100.66
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	218,392.70	232,423.10	-14,030.40	106.42
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	413,000.00	53,798.13	359,201.87	13.03
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	31,247.20	53,798.13	-22,550.93	172.17
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	381,752.80	0.00	381,752.80	0.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3.00	3.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	3.00	3.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	45.00	45.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	5.00	5.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	22.00	22.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	13.00	13.00	0.00	100.00
620004	Гэрээт ажилтан	5.00	5.00	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	45.00	45.00	0.00	100.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	13.00	13.00	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	17.00	17.00	0.00	100.00
650010	Гэрээт ажилтан	11.00	11.00	0.00	100.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	4.00	4.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	311,376.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	59,876.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36,780.35

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	785.00
210104	Урамшуулал	785.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,119.76
210301	Гэрэл, цахилгаан	4,923.72
210302	Түлш, халаалт	70.14
210303	Цэвэр, бохир ус	125.90
2104	Хангамж, бараа материалын зардал	7,433.39
210401	Бичиг хэрэг	741.84
210402	Тээвэр, шатахуун	4,086.88
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17.02
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	980.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,607.65
2105	Нормативт зардал	2,053.00
210502	Хоол, хүнс	2,053.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,120.16
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,383.50
210602	Тавилга	65.00
210604	Урсгал засвар	4,671.66
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,791.05
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,791.05
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,478.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,178.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,095.77
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	23,095.77
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	23,095.77
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	251,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	251,500.00
220001	Барилга байгууламж	30,000.00
222001	Тоног төхөөрөмж	221,500.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	311,376.13
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	311,376.13
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,060.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,703.48
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	258,791.78
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	38,820.87

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын төсвийн төвлөрүүлэн захирагч */цаашид Шаамар сумын ТТЗ гэх/* нь “Хамтарч шийдье, хөгжин дэвшье” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулсан бөгөөд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*

- Төрийн хэмнэлт тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул гэж үзлээ.

2023 онд тус ТТЗ-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дотоод хяналт, шалгалт хийгдээгүй боловч ЗДТГ-ын СТСХ-ээс төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт шалгалт хийгдсэн байна

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шаамар сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Шаамар сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад, сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүү, бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Дээрх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шаамар сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,646,147.0 мянган төгрөгөөр буюу 28.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

<i>/мянган төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	411,835.60	318,496.20	(93,339.40)
Авлага	216,071.50	200,343.80	(15,727.70)
Бараа материал	310,529.50	509,997.80	199,468.30
Үндсэн хөрөнгө	4,920,109.70	6,475,855.50	1,555,745.80
Нийт хөрөнгө	5,858,546.30	7,504,693.30	1,646,147.00
Өр төлбөр	-	154.9	154.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,858,546.30	7,504,538.40	1,645,992.10
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,858,546.30	7,504,693.30	1,646,147.00

Эх сурвалж: Шаамар сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр засгийн газрын хувь оролцоо данснуудыг дор тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 318,496.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 93,339.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

<i>/мянган төгрөгөөр/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	411,835.60	318,496.20	(93,339.40)
Төрийн сангийн харилцах	411,835.60	318,496.20	(93,339.40)
Дүн	411,835.60	318,496.20	(93,339.40)

Эх сурвалж: Шаамар сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлд тайлагнагдсан 163,532.1 мянган төгрөг ОНХО-ын дансанд, 80,697.3 мянган төгрөг ОНХС-ийн дансанд, 74,266.7 мянган төгрөг ХХС-ийн дансанд тус тус байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 200,343.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 15,727.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	886.85	0	(886.85)
Зээлийн хүүгийн авлага	12,119.66	10,682.70	(1,436.96)
Байгууллагаас авах авлага	4.08		(4.08)
Хувь хүмүүст олгосон зээл	203,060.86	189,661.10	(13,399.76)
Дүн	216,071.45	200,343.80	(15,727.65)

Эх сурвалж: Шаамар сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны эцсийн үлдэгдэлд ХХС-ийн үндсэн зээлийн 189,661.1 мянган төгрөг, зээлийн хүүгийн 10,682.7 мянган төгрөгийн авлага тайлагнагдсан байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 509,997.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 199,468.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бичиг хэргийн материал	2,434.65	2,410.65	(24.00)
Аж ахуйн материал	284,561.10	266,681.91	(17,879.19)
Сэлбэг хэрэгсэл	3,269.60	2,953.45	(316.15)
Барилгын засварын материал	1,770.00		(1,770.00)
Бусад хангамжийн материал	18,494.19	203,951.76	185,457.57
Мал амьтад		34,000.00	34,000.00
Дүн	310,529.54	509,997.77	199,468.23

Эх сурвалж: Шаамар сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд бараа материалын үлдэгдэл 199,468.2 мянган төгрөгөөр өссөн нь ОНХС-ийн хөрөнгөөр 181,249.9 мянган төгрөгийн өртөгтэй 50 ширхэг түрээсийн хүлэмж, 34,000.0 мянган төгрөгийн өртөг бүх мал худалдан авснаас голлон шалтгаалсан байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 6,475,855.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,555,745.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	4,786,501.83	6,342,410.19	1,555,908.36
Барилга, байгууламж, орон сууц	3,025,929.20	3,543,235.80	517,306.60
Авто-тээврийн хэрэгсэл	310,362.28	450,171.41	139,809.13
Машин тоног төхөөрөмж(компьютер)	79,234.51	111,807.00	32,572.49
Тавилга, аж ахуйн эд хогшил	38,992.74	35,929.21	(3,063.53)
Зам гүүрний байгууламж	125,736.12	154,177.98	28,441.86
Бусад үндсэн хөрөнгө	1,206,246.98	2,047,088.79	840,841.81
Биет бус хөрөнгө	133,607.90	133,445.30	(162.60)
Программ хангамж	3,487.90	3,325.30	(162.60)
Бусад биет бус хөрөнгө	130,120.00	130,120.00	-
Дүн	4,920,109.73	6,475,855.49	1,555,745.76

Эх сурвалж: Шаамар сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Сумын ЗДТГ нь 2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн 473,702.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй халуун усны барилга, тайлант онд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 132,000.0 мянган төгрөгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн байр,
- Сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар 264,607.6 мянган төгрөгийн гэр хорооллын дулааны шугамын өргөтгөл,
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 89,500.0 мянган төгрөгийн хогны машин, хогийн пункер,
- Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар Дулаанхаан тосгонд 18,900.0 мянган төгрөгийн приус 20 автомашин, ЗДТГ-т 19,200.0 мянган төгрөгийн Mazda автомашин,
- Хандиваар 106,275.6 мянган төгрөгийн галын автомашин хүлээн авсан байна.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөр дансны үлдэгдэл 154.9 мянган төгрөг байгаа нь ИТХ нь НДШ-ийн өглөг үүсгэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг		154.9	154.9
Байгууллагад төлөх өглөг			
Дүн	-	154.9	154.9

Эх сурвалж: Шаамар сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 7,504,538.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,645,992.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	693,139.46	693,139.46	-
Хуримтлагдсан үр дүн	3,595,549.05	5,241,541.15	1,645,992.10
Өмнөх үеийн үр дүн	11,420,690.82	3,595,549.05	(7,825,141.77)
Тайлант үеийн үр дүн	(7,825,141.77)	1,645,992.10	9,471,133.87
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,569,857.78	1,569,857.78	-
Дүн	5,858,546.29	7,504,538.39	1,645,992.10

Эх сурвалж: Шаамар сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт:

Сумын ИТХ-ын “Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 2023 оны төсөвт тодотгол хийх тухай” 2023 оны 94 дүгээр тогтоолоор тайлант онд 596,019.0 мянган төгрөгийн татварын орлого, 173,000.0 мянган төгрөгийн татварын бус орлого, нийт **769,019.0** мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр **869,657.0** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 13.1 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт № 8. Төвлөрүүлэх орлого

Татварын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	596,019.00	619,167.10	23,148.10	103.88
Хүн амын орлогын албан татвар	313,800.00	407,869.90	94,069.90	129.98
Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого	331,000.0	391,404.40	60,404.40	118.25
Хүн амын буцаан олголт	(63,000.0)	(62,918.10)		

Үйл ажиллагааны орлого	20,000.0	46,246.60	26,246.60	231.23
Хөрөнгө борлуулсны орлого	17,500.0	13,361.80	(4,138.20)	76.35
Хөрөнгийн орлого/ Хадгаламжийн хүүгийн татварын орлого/	8,300.0	19,775.20	11,475.20	238.26
Хөрөнгийн албан татвар	77,215.00	47,884.50	(29,330.50)	62.01
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	34,500.0	7,523.80	(26,976.20)	21.81
Бууны албан татвар	715.0	600.00	(115.00)	83.92
Малд ноогдуулах албан татвар	42,000.0	39,760.70	(2,239.30)	
Барааны хэрэглээ болон хэрэглэх зөвшөөрлийн бусад татвар	38,700.00	82,396.20	43,696.20	212.91
Улсын тэмдэгтийн хураамж	3,000.0	1,698.30	(1,301.70)	56.61
Хог хаягдлын хураамжийн орлого	8,500.00	5,741.40	(2,758.60)	
ТТАМАТөлбөр	27,200.0	74,956.50	47,756.50	275.58
Газрын төлбөр	165,674.00	77,754.80	(87,919.20)	46.93
Газрын төлбөр	51,819.0	52,881.70	1,062.70	102.05
Дуудлага худалдаа сонгон шалгаруулалт	113,855.0	24,873.10	(88,981.90)	21.85
Байгалийн нөөц ашигласны төлбөр	630.00	3,261.70	2,631.70	517.73
Ойн нөөц ашигласны төлбөр	-	-	-	
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	-	-	-	
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	630.0	3,261.70	2,631.70	517.73
Татварын бус бусад орлого	173,000.00	250,489.90	77,489.90	144.79
нэр заагаагүй бусад орлого	73,000.0	61,176.80	(11,823.20)	83.80
Хүү, торгуулийн орлого	100,000.0	189,313.10	89,313.10	189.31
Нийт дүн	769,019.00	869,657.00	100,638.00	113.1

Эх сурвалж: Шаамар сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд цалин хөлс, түүнтэй адилтгах орлого 60,404.4 мянган төгрөгөөр, ТТАМАТ-ын орлого 47,756.5 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны орлого 26,246.6 мянган төгрөгөөр, татварын бус бусад орлого болох хүү, торгуулийн орлого 89,313.1 мянган төгрөгөөр давж биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- **Цалин хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлого:** Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор цалин хөлс, шагнал, урамшуулал болон түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогоос суутган тооцох татварын орлого нэмэгдэж, 60,404.4 мянган төгрөгөөр,
- **ТТАМАТ-ын орлого:** Замын ажилтай холбоотой хайрга ашигласны төлбөрийн орлого 47,756.5 мянган төгрөгөөр,
- **Хүү, торгуулийн орлого:** Тайлант онд аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгаас тус сумын нутаг дэвсгэрт аян зохион байгуулж ажилласан болон Дулаанхан 4 замын Цагдаагийн посттой холбоотойгоор тус орлого 89,313.1 мянган төгрөгөөр давж биелсэн байна.

Тасарсан орлого:

- **Дуудлага худалдаа:** Тайлант онд 2 удаа газрын дуудлага зохион байгуулсан боловч эхний дуудлага худалдаанд оролцогч ирээгүйгээс шалтгаалан хүчингүй болсон,
- **Үл хөдлөх хөрөнгийн албан татвар:** Орлогын төлөвлөгөөг хэт өндөр төлөвлөснөөс шалтгаалж тасарсан байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Шаамар сумын ТТЗ-ийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 1,260,391.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 72 дугаар тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 769,019.0 мянган төгрөг, ерөнхий орлогын оны эхний үлдэгдлээс 256,000.0 мянган төгрөг, ОНХС-ийн оны эхний үлдэгдлээс 72,000.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлэг 234,137.1 мянган төгрөг, ХХС-ийн эхний үлдэгдлээс 49,272.8 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 50,727.2 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 1,172,812.6 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 15,000.0 мянган төгрөг зэрэг нийт 2,618,968.7 мянган төгрөгийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлэхээр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 118 дугаар тогтоолоор аймгийн 2023 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2023 оны 94 дүгээр тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 769,019.0 мянган төгрөгөөр, урьд оны ерөнхий орлогын дансны үлдэгдлээс 260,480.0 мянган төгрөг, ОНХС-ийн эхний үлдэгдлээс санхүүжих дүнг 72,000.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 218,392.7 мянган төгрөгөөр, ХХС-ийн эхний үлдэгдлээс 49,272.8 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 16,247.2 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 1,488,774.7 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 15,000.0 мянган төгрөг зэрэг нийт 2,889,186.4 мянган төгрөгийн санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлж, зарцуулахаар баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 2,272,644.1 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас 232,423.1 мянган төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангаас 30,598.6 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 23,199.5 мянган төгрөг зэрэг нийт **2,558,865.3** мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлж, 2,496,010.7 мянган төгрөгийг зарцуулан зардлын гүйцэтгэл **86.4** хувьтай тайлагнагдсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин, НДШ-ийн зардал 38,850.4 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 32,501.6 мянган төгрөгөөр, хангамжийн материалын зардал 12,080.3 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 1,255.0 мянган төгрөгөөр,

томилолтын зардал 1,668.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 20,398.9 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 24,404.4 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг 2,153.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын хөрөнгө оруулалтаар нийт 14 төсөл, арга хэмжээнд 604,805.1 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 454,720.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 4 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 14 төсөл, арга хэмжээнд 332,392.7 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 288,342.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 5 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн ЗДНХ-өөс 15,163.4 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас 221,500.0 мянган төгрөг, ОНХО-аас 30,000.0 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс мал тооллогын зардалд 1,291.8 мянган төгрөг, ГБХЗХГ-аас хүүхдийн чуулга, уулзалтын зардалд 600.0 мянган төгрөг, Монголиан транс ложистик компаниас ахмадын баяр болон баяр наадмын зардалд зориулж 4,000.0 мянган төгрөгийн хандивын орлого, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 38,820.9 мянган төгрөг зэрэг нийт 311,376.1 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд аймаг, сумдын ОНХО, ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн харьцуулалтын болон нээлттэй тендер шалгаруулалтын аргаар гүйцэтгэх 8 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад бүрэн байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

Хөрөнгө оруулалтын ажлын эх үүсвэр	Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ		Харьцуулалтын арга			
	Тоо	дүн	Харьцуулалтын арга		НТШ	
			тоо	дүн	тоо	дүн
Сумын ОНХС	1	206,237.10			1	206,237.10
Сумын ОНХО	5	471,305.10	4	188,200.00	1	283,105.10

Аймгийн ОНХС	2	228,281.70	1	96,281.70	1	132,000.00
--------------	---	------------	---	-----------	---	------------

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шаамар сумын ТТЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Шаамар сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/33 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлын 1,380,990.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 13,809.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд нийт зардал их хэмжээгээр өөрчлөгдсөн тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 2,313,498.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцон **23,134.9** мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус сум нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Шатахууны зардлыг хэмнэх зорилгоор автомашинуудад байршил тогтоогч суурилуулсан,
- Автомашинуудад цэнхэр дугаар авсан,
- Ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувилал, төрсөн нутагтаа амрах тохиолдолд очих, ирэх замын зардлыг олгоогүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Баяр ёслол, тэмдэглэлт өдрүүд, бусад арга хэмжээнүүдтэй холбогдуулан контент, аялал зугаалга, уралдаан тэмцээн зохион байгуулаагүй зэрэг төсвийн захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүснэгт 10. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байдал

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн тоо	Хугацаа хоцроосон
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	170	160	5
2	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	161	158	3
3	Сумын Засаг даргын Тамгын газар	161	160	1
4	Дулаанхаан тосгоны Захирагчийн алба	161	161	
	Нийт дүн	653	645	8

Эх сурвалж: www.old.shilendans.gov.mn

Тайлант хугацаанд ТТЗ, харьяа байгууллагуудын мэдээлбэл зохих 18-20 төрлийн нийт 653 мэдээллээс 645 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 122 дугаар “Санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 11. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,982.1	1	1,982.1	100.0
Албан шаардлага	9	339,797.0	9	339,797.0	100.0
Зөвлөмж	3	12,000.0	3	12,000.0	100.0
Нийт дүн	13	353,779.1	13	353,779.1	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХО, ОНХС-ийн эх үүсвэрээр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагналтай холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитад бүрэн хамруулах боломжгүй байлаа.

Иймээс “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн”, “ОНХС-ийн 2023 оны хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

2. Аймгийн ОНХС-аас 2022 онд эрх шилжүүлсэн 263,179.2 мянган төгрөгийн өртөгтэй “Сумын төв доторх авто зам сайжруулахад шаардагдах цемент, материал худалдан авах” төсөл, арга хэмжээний хүрээнд худалдан авсан цемент болон бусад материалаар 2023 оны 6 дугаар сард явган хүний замын болон автозамын хашлага, ЗДТГ, цэцэрлэг, эмнэлэг, ЕБС-ийн авто зогсоол зэрэг ажлуудыг хийхэд 65.6 тонн цемент зарцуулж, хийгдсэн ажлуудыг бүртгэлд тусгасан байна. Харин ашиглагдаагүй буюу Дэвжих таван хан ХХК-ийн агуулахад хадгалуулсан 384.4 тонн цементийг үлдэгдлээр тайлагнасан байна. Үлдэгдэл цементийн зарцуулалт, чанарын шаардлага хангаж буй эсэхийг “ОНХС-ийн 2023 оны хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай.

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 40,842.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 851.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 39,991.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, зөрчлийг арилгах 1 зөвлөмж хүргүүллээ.

5.1 Төлбөрийн акт:

1. Сумын ЗДТГ-ын 7 албан хаагчид 851.5 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг илүү тооцож, олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан *"Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3.3-д " Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна"* гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэмэгдэл хөлсийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага:

1. Холбогдох байгууллагын шийдвэргүйгээр сумын ЗДТГ нь 8,079.0 мянган төгрөгийн, Дулаанхаан тосгоны Захирагчийн алба 9,720.3 мянган төгрөгийн төлөвлөгөөнөөс давсан өөрийн орлогыг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4-д *"Туслах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг төсвийн жилийн дундуур авсан бол түүний төсвийг нэмэлт төсөв хэлбэрээр, бусад тохиолдолд тухайн жилийн төсөвт тусган хэрэгжүүлнэ."*, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан *"Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 4.2-д " Орон нутгийн төсөвт байгууллагын ... энэ журмын 3.1.1-т заасан орлогыг зарцуулах хүсэлтийг аймаг, ... сум .. Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс энэхүү журмын 4.1-д заасан хугацааны дотор хянаж тухайн шатны Засаг даргын захирамжаар шийдвэрлэнэ. "* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өөрийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж, зарцуулах эрх авсны үндсэн дээр зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Сумын хөрөнгө оруулалтаар шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн 12,500.0-15,800.0 мянган төгрөгийн зах зээлийн үнэ бүхий Мазда-бонго автомашиныг /2006 онд үйлдвэрлэгдэж, 2021 онд Монгол орж ирсэн / Мөнхбилэг хутагт ХХК-аас 19,200.0 мянган төгрөгөөр, 11,000.0-15,200.0 мянган төгрөгийн зах зээлийн үнэ бүхий Приус 20 автомашиныг /2005 онд үйлдвэрлэгдэж, 2020 онд Монгол орж ирсэн / Бумт оргил констракшн ХХК-аас 18,900.0 мянган төгрөгөөр тус тус худалдан авсан байна. Өөрөөр хэлбэл зах зээлийн үнээс Мазда бонго автомашиныг 3,400.0-6,700.0 мянган

төгрөгөөр, Приус 20 автомашиныг 3,700.0-7,900.0 мянган төгрөгөөр тус тус зах зээлийн үнээс өндөр үнээр худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шууд худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа зах зээлийн үнийн судалгаа хийж, үр ашигтай, хэмнэлттэй байх зарчмыг баримтлан ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3. Сумын ЗДТГ нь бараа үйлчилгээний бусад зардлаас тавилга, эд хогшил худалдан авахад 1700.0 мянган төгрөгийг, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас автомашины сэлбэг авахад 4073.3 мянган төгрөгийг тус тус гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

4. Дулаанхаан тосгоны Захирагчийн алба нь Монголиан транс ложистик компаниас ахмадын баяр болон баяр наадмын зардалд зориулж 4,000.0 мянган төгрөгийн хандив авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-д “Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн доор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно: 25.2.1.эмнэлгийн үйлчилгээ; 25.2.2.бүх шатны боловсролын үйлчилгээ; 25.2.3.соёлын үйлчилгээ.” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Бусдаас хандив, тусламж авахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5. ЗДТГ-ын дарга Д.Энхзаяаг 2023 оны 1 дүгээр сараас эхлэн нууцын ажилтнаар томилж, нэмэгдэл цалинг 10 хувиар тогтоон олгож байгаад өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу ЭБАТ-ны нэмэгдлийг 2023 оны 05 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн 15 хувиар бууруулж, нууцын нэмэгдлийг 15 хувиар нэмэгдүүлэн, 1,168.4 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон албаны нууц хамгаалах ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журам”-ын 2.1 дэх “Нууц хамгаалах ажилтны цалингийн

нэмэгдлийг түүний ажлын ачаалал, хариуцаж байгаа нууцын зэрэглэл, нууцтай ажилласан хугацаа зэргийг харгалзан тухайн ажилтны албан тушаалын үндсэн цалингийн 10-30 хувиар тооцож, сар бүр олгоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нууцын ажилтны цалингийн нэмэгдлийг ажлын ачаалал, хариуцаж байгаа нууцын зэрэглэл, нууцтай ажилласан хугацаа зэргийг харгалзан бодитоор тогтоох албан шаардлага хүргүүлэв.

6. ЗДТГ нь өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөрөөр тайлагнагдаагүй, ээж модны үнэлгээний зардлын 400.0 мянган төгрөгийг тайлант оны зардлаас санхүүжүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.3: бүх өр төлбөр...*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын үлдэгдлийг баталгаажуулж, авлага, өр төлбөрийг бүрэн тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

1. Газрын эзэмшил, бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Төрийн мэдээлэл солилцооны хур системд тухайн байгууллагын эзэмшилд 16 газар бүртгэлтэй байгаа боловч санхүүгийн тайланд 5 газар нь бүртгэгдэж, тайлагнагдаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ*”: 14.4.2-д “*бүх хөрөнгө, ...*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Дээрх газруудын эзэмших эрхийн асуудлыг холбогдох байгууллагуудад уламжилж, шийдвэрлүүлэх, бүртгэл тайланд тусгах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5¹ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй			
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шаамар сумын ТТЗ	9	40,842.5	1	851.5	6	39,991.0	1	-				
Дүн	9	40,842.5	1	851.5	6	39,991.0	1	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс		Зөвлөмж
		Төлбөрийн акт	Албан шаардлага	

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Нийт 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	-					1	